

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/126/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	25-26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОГ	Байгаль орчны газар
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
З.ТҮВШИНТӨГС ТАНАА

2025.02.25 № СГА-2025/126/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 142 дугаар тогтоолын дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2024 оны төсвийн жилд 9 төсөл, арга хэмжээг 560,000.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2023 оны А/528 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тоог 71 хүнээр баталсан боловч тайлант онд гүйцэтгэлээр 54 албан хаагч ажилласан.

Сумдын байгаль хамгаалагч 11, ойн нөхөрлөл, ойн менежмент хариуцсан мэргэжилтэн, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хүрээлэн буй орчны албаны дарга, санхүү, үйлчилгээний албаны дарга, сантехникч, ойжуулалт, мод

үржүүлэг, байгалийн ургамлын асуудал хариуцсан мэргэжилтэн тус бүр 1 нийт 17 орон тоо дутуу ажилласан байна.

Тайлант онд орон тоо дутуу ажилласан, 10 албан тушаалыг хавсран гүйцэтгүүлснээс голлон шалтгаалж, цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 467,440.2 мянган төгрөгөөр хэмнэсэн нь нийт хэмнэсэн зардлын 76.4 хувийг эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт, 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,773,183.00	58,757,004.00
33	АВЛАГА	-	1,815.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,815.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,773,183.00	58,755,189.00
35100	Түүхий эд материал	1,500,000.00	1,500,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,500,000.00	1,500,000.00
35400	Хангамжийн материал	21,273,183.00	57,255,189.00
35410	Бичиг хэргийн материал	3,550,350.00	2,825,200.00
35420	Аж ахуйн материал	2,271,250.00	3,552,000.00
35440	Түлш, шатах тослох материал	451,150.00	645,150.00
35470	Бусад хангамжийн материал	15,000,433.00	50,232,839.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	240,093,403.94	234,033,131.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	240,093,403.94	234,033,131.69
39200	Биет хөрөнгө	196,686,753.73	185,914,631.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,838,740.00	43,164,071.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,962,002.17)	(40,875,782.83)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,950,000.00	55,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,687,500.27)	(38,012,500.35)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	162,707,120.88	186,780,362.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,145,873.12)	(95,647,414.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,492,849.88	108,052,552.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,722,925.22)	(37,291,658.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,600,300.00	21,600,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,383,956.25)	(17,805,300.00)
39300	Биет бус хөрөнгө	43,406,650.21	48,118,500.25
39301	Програм хангамж	65,147,600.00	65,147,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(21,940,949.79)	(38,085,099.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	200,000.00	21,056,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	262,866,586.94	292,790,135.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	262,866,586.94	292,790,135.69
51	Засгийн газрын хувь оролцоо	262,866,586.94	292,790,135.69
51100	Засгийн газрын оруулсан капитал	121,834,119.85	121,834,119.85
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	121,834,119.85	121,834,119.85
51200	Хуримтлагдсан үр дүн	139,647,243.97	169,570,792.72
51210	Өмнөх үеийн үр дүн	47,814,707.49	139,647,243.97
51220	Тайлант үеийн үр дүн	91,832,536.48	29,923,548.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,385,223.12	1,385,223.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,201,279,800.05	2,934,396,170.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,007,366.54	28,389,607.92
120	Нийтлэг татварын бус орлого	35,007,366.54	28,389,607.92
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	34,277,366.54	27,759,607.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	730,000.00	630,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,166,272,433.51	2,906,006,562.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,382,201.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,382,201.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,152,890,232.51	2,906,006,562.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,152,890,232.51	2,906,006,562.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,109,447,263.57	2,833,326,927.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,109,447,263.57	2,833,326,927.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,075,140,403.57	2,622,199,973.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,096,813,193.15	1,783,904,846.26
210101	Үндсэн цалин	597,052,232.73	878,428,084.22
210102	Нэмэгдэл	332,468,023.88	626,285,599.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,949,160.54	183,296,548.75
210104	Урамшуулал	90,343,776.00	95,894,613.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,720,902.93	220,407,078.01
210201	Тэтгэврийн даатгал	94,280,717.12	152,987,644.90
210202	Тэтгэмжийн даатгал	11,077,614.17	17,827,284.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,787,288.54	9,125,599.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,057,585.03	8,017,507.20
210205	Эрүүл мэндийн даатгал	20,517,698.07	32,449,041.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,680,937.36	47,414,884.83
210301	Гэрэл, цахилгаан	768,959.36	5,741,146.83
210302	Түлш, халаалт	30,527,198.00	40,173,118.00
210303	Цэвэр, бохир ус	384,780.00	1,500,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,353,912.07	33,903,097.40
210401	Бичиг хэрэг	5,096,150.00	4,965,150.00
210402	Тээвэр, шатахуун	15,700,000.00	21,163,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,335,462.07	1,867,127.40
210404	Ном, хэвлэл	84,000.00	48,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,138,300.00	3,274,170.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,385,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,974,500.00	39,607,900.00
210604	Урсгал засвар	49,974,500.00	39,607,900.00
2107	Томилолт, зочны зардал	17,971,300.00	20,768,500.00
210702	Дотоод албан томилолт	17,971,300.00	20,768,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,193,685.00	1,148,985.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,860.00	140,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,596,700.00	544,000.00
210807	Газрын төлбөр	100,200.00	100,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,698,431,973.06	475,044,682.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,653,293,203.00	397,040,559.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,928,770.06	78,004,122.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,306,860.00	211,126,954.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,209,260.00	211,126,954.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,408,960.00	47,554,032.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	144,989,217.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,800,300.00	18,583,705.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,600.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	97,600.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	91,832,536.48	101,069,242.67
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	71,145,693.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	71,145,693.92
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	91,832,536.48	29,923,548.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,166,272,433.51	2,906,006,562.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,166,272,433.51	2,906,006,562.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,382,201.00	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,382,201.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,152,890,232.51	2,906,006,562.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,152,890,232.51	2,906,006,562.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,066,417,243.51	2,861,822,320.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,066,417,243.51	2,861,822,320.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,032,110,383.51	2,650,695,366.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,096,813,193.15	1,783,904,846.26
210101	Үндсэн цалин	597,052,232.73	878,428,084.22
210102	Нэмэгдэл	332,468,023.88	626,285,599.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,949,160.54	183,296,548.75
210104	Урамшуулал	90,343,776.00	95,894,613.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,720,902.93	220,408,893.01
210201	Тэтгэврийн даатгал	94,280,717.12	152,987,644.90
210202	Тэтгэмжийн даатгал	11,077,614.17	17,827,284.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,787,288.54	9,125,599.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,057,585.03	8,017,507.20
210205	Эрүүл мэндийн даатгал	20,517,698.07	32,450,856.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,680,937.36	47,414,884.83
210301	Гэрэл, цахилгаан	768,959.36	5,741,146.83
210302	Түлш, халаалт	30,527,198.00	40,173,118.00
210303	Цэвэр, бохир ус	384,780.00	1,500,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,254,012.07	31,841,197.40
210401	Бичиг хэрэг	5,096,150.00	5,090,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,700,000.00	19,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,335,462.07	1,867,127.40
210404	Ном, хэвлэл	84,000.00	48,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,038,400.00	4,836,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,974,240.00	39,585,400.00
210604	Урсгал засвар	49,974,240.00	39,585,400.00
2107	Томилолт, зочны зардал	17,971,300.00	20,748,500.00
210702	Дотоод албан томилолт	17,971,300.00	20,748,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,193,685.00	1,608,985.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,860.00	140,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,596,700.00	674,000.00

210807	Газрын төлбөр	100,200.00	100,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,655,502,113.00	505,182,659.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,655,292,113.00	505,182,659.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,306,860.00	211,126,954.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,209,260.00	211,126,954.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,408,960.00	47,554,032.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	144,989,217.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,800,300.00	18,583,705.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,600.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	97,600.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	99,855,190.00	44,184,242.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	99,855,190.00	44,184,242.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99,855,190.00	44,184,242.00
2200	Дотоод эх үүсвэрээр	99,855,190.00	44,184,242.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	99,855,190.00	44,184,242.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(99,855,190.00)	(44,184,242.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	47,814,707.49	171,034,050.46
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	47,814,707.49	171,034,050.46
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	91,832,536.48	91,832,536.48
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	139,647,243.97	262,866,586.94
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	139,647,243.97	262,866,586.94
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	139,647,243.97	262,866,586.94
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	29,923,548.75	29,923,548.75
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	169,570,792.72	292,790,135.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,517,551,300.00	2,906,006,562.60	611,544,737.40	82.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,517,551,300.00	2,906,006,562.60	611,544,737.40	82.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,219,645,000.00	2,694,879,608.40	524,765,391.60	83.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,193,503,500.00	1,783,904,846.26	409,598,653.74	81.33
210101	Үндсэн цалин	1,015,903,900.00	878,428,084.22	137,475,815.78	86.47
210102	Нэмэгдэл	841,611,500.00	626,285,599.69	215,325,900.31	74.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	163,947,000.00	183,296,548.75	(19,349,548.75)	111.80
210104	Урамшуулал	172,041,100.00	95,894,613.60	76,146,486.40	55.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,250,500.00	220,408,893.01	57,841,606.99	79.21
210201	Тэтгэврийн даатгал	189,210,200.00	152,987,644.90	36,222,555.10	80.86
210202	Тэтгэмжийн даатгал	22,260,000.00	17,827,284.82	4,432,715.18	80.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,138,000.00	9,125,599.76	(987,599.76)	112.14
210204	Ажилгүйдлийн даатгал	14,122,200.00	8,017,507.20	6,104,692.80	56.77
210205	Эрүүл мэндийн даатгал	44,520,100.00	32,450,856.33	12,069,243.67	72.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,771,600.00	47,414,884.83	3,356,715.17	93.39
210301	Гэрэл, цахилгаан	8,022,700.00	5,741,146.83	2,281,553.17	71.56
210302	Түлш, халаалт	39,657,000.00	40,173,118.00	(516,118.00)	101.30
210303	Цэвэр, бохир ус	3,091,900.00	1,500,620.00	1,591,280.00	48.53
2104	Хангамж, бараа материалын зардал	31,841,200.00	31,841,197.40	2.60	100.00
210401	Бичиг хэрэг	6,240,000.00	5,090,000.00	1,150,000.00	81.57
210402	Тээвэр, шатахуун	20,000,000.00	19,800,000.00	200,000.00	99.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,288,300.00	1,867,127.40	421,172.60	81.59
210404	Ном, хэвлэл	84,000.00	48,000.00	36,000.00	57.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	200,000.00	(200,000.00)	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,228,900.00	4,836,070.00	(1,607,170.00)	149.77
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,869,000.00	82,654,242.00	214,758.00	99.74
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,158,000.00	22,957,842.00	200,158.00	99.14
210602	Тавилга	20,111,000.00	20,111,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	39,600,000.00	39,585,400.00	14,600.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	20,800,000.00	20,748,500.00	51,500.00	99.75
210702	Дотоод албан томилолт	20,800,000.00	20,748,500.00	51,500.00	99.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,609,200.00	1,608,985.00	215.00	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	438,000.00	438,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	200,925.00	75.00	99.96
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,000.00	140,860.00	140.00	99.90
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	674,000.00	674,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	100,200.00	100,200.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	560,000,000.00	506,298,059.90	53,701,940.10	90.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	560,000,000.00	506,298,059.90	53,701,940.10	90.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	297,906,300.00	211,126,954.20	86,779,345.80	70.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	297,906,300.00	211,126,954.20	86,779,345.80	70.87
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81,042,300.00	47,554,032.00	33,488,268.00	58.68
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	198,264,000.00	144,989,217.20	53,274,782.80	73.13
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,600,000.00	18,583,705.00	16,295.00	99.91
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,517,551,300.00	2,906,006,562.60	611,544,737.40	82.61
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,517,551,300.00	2,906,006,562.60	611,544,737.40	82.61
320001	Орон нутгийн төсвөөс	3,517,551,300.00	2,906,006,562.60	611,544,737.40	82.61
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	143.00	109.00	34.00	76.22
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	71.00	54.00	17.00	76.06
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	65.00	48.00	17.00	73.85
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	71.00	54.00	17.00	76.06
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	58.00	44.00	14.00	75.86
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	10.00	3.00	76.92

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газар *Цаашид БОГ гэх* нь “Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн хууль тогтоомжуудыг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх замаар байгаль орчны тэнцлийг хангаж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Байгаль орчны багц хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх,
- Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх,
- Байгаль орчны сургалт, сурталчилгааны ажлыг гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах,
- Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх,
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах,
- Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

БОГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

БОГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

БОГ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

БОГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,923.5 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	-	1.82	1.82
Бараа материал	22,773.18	58,755.19	35,982.01

Үндсэн хөрөнгө	240,093.40	234,033.13	(6,060.27)
Нийт хөрөнгө	262,866.58	292,790.14	29,923.56
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	262,866.58	292,790.14	29,923.56
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	262,866.58	292,790.14	29,923.56

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 58,755.2 мянган төгрөг болж 35,982.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 154,471.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 118,489.6 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас голлон шалтгаалсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 234,033.1 мянган төгрөг болж, 6,060.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 44,184.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 160 дугаар тогтоолоор аймгийн ОНӨГ-аас 62,630.0 мянган төгрөгийн барилга, тавилга эд хогшил, газрыг шилжүүлэн авсан, тайлант онд 112,874.5 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,224,330.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, аймгийн ТЕЗ-д хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 818,109.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 16,218.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 35,060.0 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 48,836.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг /БОХНСАХ-ний зардал/ 579,029.0 мянган төгрөг зэрэг нийт 1,524,334.4 мянган төгрөгөөр бууруулж, 3,699,996.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 1,349,725.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 82,869.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 216,864.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, бараа үйлчилгээний бусад зардлыг /БОХНСАХ-ний зардал/ 1,832,988.6 мянган төгрөгөөр бууруулсан зэргээр батлагдсан төсвийг нийт 182,444.9 мянган төгрөгөөр бууруулж, 3,517,551.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,517,551.3 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 2,906,006.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,906,006.6 мянган төгрөг буюу 82.6 хувьтай тайлагнагдсан нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 467,706.7 мянган төгрөгөөр, төрийн өмчийн барилгын тогтмол зардлыг 3,356.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийг 86,779.4 мянган төгрөгөөр, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 53,701.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71413	Байгал орчин хамгаалах нөхөн сэргээх				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,608,873.40	2,141,166.70	467,706.70	82.07
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	50,771.60	47,414.90	3,356.70	93.39
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	297,906.30	211,126.90	86,779.40	70.87
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	560,000.00	506,298.10	53,701.90	90.41
	Дүн	3,517,551.30	2,906,006.60	611,544.70	82.61

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130013402 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

БОХНСАХ-ний төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан шууд худалдан авах босго үнээс давсан 4 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ХААГ-аар зохион байгуулуулсан байна.

Үүнээс 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах зарыг tender.gov.mn цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Үүнд:

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Сонгон шалгарсан аж ахуйн нэгжийн нэр
1	Орхон, Алтанбулаг, Сайхан сумдад байгуулсан хамгаалалтын ойн зурвасын усалгааны эх үүсвэрийг шийдэх	105,000.00	74,260.50	Гранд холдинг ХХК
2	Хөв цөөрөм байгуулах	223,470.00	218,134.30	Сэлэнгэ-Ундрэм ХХК
3	Байгаль хамгаалагчдыг мотоциклоор хангах	60,000.00	56,500.00	АЕ ложистик групп ХХК
4	Байгаль орчны салбарын албан хаагчдыг хөдөө ажиллах нөхцөлөөр хангах	46,530.00	46,016.00	Гэгээн үүл хээ ХХК
	Дүн	435,000.00	394,910.80	

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

БОГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 65 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,109,447.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 31,094.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй, байгууллагын гэрэл, цахилгааны хэрэглээг хэмнэсэн зэргээр төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд БОГ-ын мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 27 төрлийн 181 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт”, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал” 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

2. БОХНСАХ-ний зардлаас хэрэгжүүлэх дараах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 50-80 хувиар урьдчилгаа олгох гэрээ байгуулж, санхүүжилтийг урьдчилж олгосон байна. Үүнд:

- Гранд холдинг ХХК-тай байгуулсан “Орхон, Алтанбулаг, Сайхан сумдад байгуулсан хамгаалалтын ойн зурвасын усалгааны эх үүсвэрийг шийдэх” төсөл, арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтийг 70 хувиар олгохоор тооцож 74,480.5 мянган төгрөг,
- Сэлэнгэ-Ундрам ХХК-тай байгуулсан “Хөв цөөрөм байгуулах” төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 50 хувь буюу 111,614.3 мянган төгрөг,
- Гэгээн үүл хээ ХХК-тай байгуулсан “Байгаль орчны салбарын албан хаагчдыг хөдөө ажиллах нөхцөлөөр хангах” төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 80 хувь буюу 36,812.8 мянган төгрөгийн урьдчилгааг тус тус олгосон байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх “Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө”, 44.3 дахь “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх ажил үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, тендерийн баримт бичигт заасан шалгуурт нийцүүлэн зохион байгуулж, урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулж байх зөвлөмж хүргүүлэв.

3. БОХНСАХ-ний зардлаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний батлагдсан төсвөөс “Байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулах” үйл ажиллагаанд 20,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5-д “Энэ журмын ... аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ: 3.5.1: хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгаа хийх ...”, 3.6.16-д “нутаг дэвсгэртээ идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх нутгийн иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх **сургалт** зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид БОХНСАХ-ний зардлыг холбогдох хууль, эрхийн актад заасан төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, худалдан авах ажиллагаа, БОХНСАХ-ний зардлаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Шилэн дансны тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар БОХНСАХ-ний эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид **4,805.6** мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон зөрчилд төлбөрийн акт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулаагүй, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан 2 зөрчилд **5,328.5** мянган төгрөгийн албан шаардлага, үнэ, өртгийн судалгаа, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг БОХНСАХ-ний зардалд төлөвлөж, хэрэгжүүлсэн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,805.6	1	4,805.6	100
Албан шаардлага	2	5,328.5	2	5,328.5	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	4	10,134.1	2	13,023.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд аймгийн ИТХ-ын 2023 оны 142 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ”-ний санхүүжилтийн гүйцэтгэлийг аудитын явцад түүвэрлэн үзсэн бөгөөд тендер, сонгон шалгаруулалтай холбоотой асуудлыг аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитад бүрэн хамруулаагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **37,994.1** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **3,671.5** мянган төгрөгийн төлбөрийн акт, **26,680.0** мянган төгрөгийн албан шаардлага, **7,642.6** мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт:

1. Албан хаагчдын цалин, нэмэгдэл, урамшуулалтай холбоотой **3,671.5** мянган төгрөгийн дараах зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 4 дүгээр сарын цалингаас тооцож, **1,465.0** мянган төгрөгийг илүү олгосон,
- Нягтлан бодогч Б.Минжээгийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 50.0 хувиар тооцож олгосон боловч аймгийн Засаг даргын 2024 оны Б/24 дүгээр захирамжийг үндэслэн БОГ-ын даргын 2024 оны Б/21 дүгээр тушаалаар байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хууль журам, стандартын дагуу бэлтгэж аудитын тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр **2,206.5** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин, нэмэгдэл, урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Хүний нөөц хангалтгүй гэх үндэслэлээр төрийн албан хаагчдаар үйлчилгээний албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, цалинг хавсран гүйцэтгэсэн албан тушаалын үндсэн цалингаар тооцон **26,680.0** мянган төгрөгийн нэмэгдэл цалин /50.0 хувиас хэтэрсэн/ олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ” 37.1.17: “Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх “Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ”, 38.1.6: “Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх”, 38.1.7: “Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх....”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 57 дугаар зүйлийн 57.3, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Ойжуулалт, мод үржүүлэг, байгалийн ургамлын асуудал хариуцсан мэргэжилтэн Ө.Отгон-Эрдэнэд хууль, эрх зүй, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтны үүргийг

хавсран гүйцэтгүүлж, “Хавсран ажиллах гэрээ” байгуулж, гэрээний 2.3-т “цалин хөлс - харилцан тохиролцсоноор” гэж тусгасны дагуу нэмэгдэлд 11,129.5 мянган төгрөг,

- Нягтлан бодогч Б.Минжээд Санхүү үйлчилгээний албаны даргын ажлыг хавсран гүйцэтгүүлж, “Ажил хавсруулан гүйцэтгүүлэх гэрээ” байгуулж, гэрээний 4.1-д “ажлын хөлс – ТҮ-10 шатлалын үндсэн цалин ...” гэж тусгасны дагуу нэмэгдэлд 4,706.2 мянган төгрөг,
- Архив, бичиг хэргийн ажилтан Х.Сэлэнгэд нярвын үүрэгт ажлыг хавсран гүйцэтгүүлж, “Хавсран ажиллах гэрээ” байгуулж, гэрээний 2.3-т “цалин хөлс - харилцан тохиролцсоноор” гэж тусгасны дагуу нэмэгдэлд 1,337.0 мянган төгрөг.
- Тус байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/83 дугаар тушаалаар Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын ажилтан Д.Энх-Амартай “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ” байгуулж, сүлжээний инженерээр ажиллуулан цалинг ТҮ-7-1 шатлалаар тооцон **9,507.3** мянган төгрөг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Сул ажлын байрыг нийтэд зарлан, төрийн албан хаагчдаар ажил хавсран гүйцэтгүүлэхгүй байх, зайлшгүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу цалин хөлс олгож байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой

Илрүүлэлт: “Хамгаалалтын зурвасын усалгааны эх үүсвэр шийдэх”, “Хөв цөөрөм байгуулах” 2 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэл, фото зургаар баталгаажуулаагүйгээр **7,642.6** мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.17 дахь “Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж: Магадалшгүй ажлын зардлыг журмын дагуу тооцож, олгож байх.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн		
Дүн										

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг илүү буюу давхардуулан тооцож, олгосон.	1	3,671.5	1	3,671.5								
Төрийн албан хаагчдаар ажил хавсран гүйцэтгүүлж, цалин хөлс олгосон.	1	26,680.0			1	26,680.0						
Магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэл, фото зургаар баталгаажуулаагүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр олгосон.	1	7,642.6					1	7,642.6				

/мянган төгрөгөөр/

Дүн	3	37,994.1	1	3,671.5	1	26,680.0	1	7,642.6		
-----	---	----------	---	---------	---	----------	---	---------	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй.	1	-					1	-
Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр санхүүжилтийг урьдчилж олгосон.	1	-					1	-
БОХНСАХ-ний зардлаар зориулалт бус арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн	1	-					1	-
Дүн	3	-					3	-
Нийт дүн	4	-					4	-